



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилт от түвшин	Хугацаа /I-IV улирал/	Хариуцах нэгж	Гүйцэтгэлийн хувь
<p align="center">ЗОРИЛГО.УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ.</p> <p align="center">/“Алсын хараа-2050” зорилт 5.3, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.3, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.1, Улсын бүртгэлийн байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө, Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Аймгийн “Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5.1.1/</p>								
<p align="center">Зорилт1. Инновацийг дэмжигч, итгэл хүлээсэн, ил тод, нээлттэй төрийн үйлчилгээний байгууллага байна.</p>								
1.1	Цахим гадаад паспортыг хэрэглээнд нэвтрүүлэх	-	Цахим гадаад паспортыг хэрэглээнд нэвтрүүлэх гүйцэтгэлийн хувь	20	50	I-IV улирал	Цахим гадаад паспортын захиалгыг 3 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн авч эхэлсэн ба 11 дүгээр сарын 25-ны байдлаар 3739 иргэнд олгосон байна.	100%
1.2	Тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулах	-	-Хүсэлт гаргасан иргэдэд олгосон тоон гарын үсгийн хувь	30	50	I-IV улирал	Улсын бүртгэлийн байгууллагаас тоон гарын үсгийг 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн иргэдэд олгож эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар тус хэлтсээс нийт 48.248 иргэнд тоон гарын үсэг олгосноос гар утасны аппликейшнд 1805, иргэний үнэмлэхний чипэнд 46.443 иргэнд тоон гарын үсэг олгосон ба 16 ба түүнээс дээш насны иргэдийн 65,7%-д олгогдсон байна. Тоон гарын үсэг олгох ажлын хүрээнд идэвхи санаачлага гарган хамгийн хүн ам ихтэй Өлгий сумын Засаг даргатай хамтран удирдамж баталж Өлгий сумын 13 багийн дунд “Тоон гарын үсэг олголтыг идэвхжүүлэх сарын аян” зохион байгуулан ажилласан. Тоон гарын үсэг олголтыг	100%

							эрчимжүүлэх ажлын хүрээнд УБЕГ болон ХААН банкттай хамтран зохион байгуулсан аянд идэвхтэй оролцож 4, 5 дугаар сард улсын хэмжээнд 2 удаа 2 дугаар байранд шалгарч 1,6 сая төгрөгөөр шагнагдсан болно.	
1.3	Иргэний бүртгэлийн дугаарыг хэрэглээнд нэвтрүүлж, шинэчилсэн загвар бүхий бэлдцэд бичилт хийх, хэвлэх	-	Шинэчилсэн загвараар иргэний үнэмлэх олгосон тоо	280	4500	I-IV улирал	Иргэний бүртгэлийн дугаарыг 2022 оны 10 дугаар сарын 18-ний өдрөөс эхлэн хэрэглээнд нэвтрүүлэн олгож эхэлсэн ба хэвлэгдэн гарч байгаа нийт 8366 үүнээс: иргэний үнэмлэхний 4690, төрөлтийн 2518, гэрлэлтийн 553, нас баралтын 605 бүртгэлийн гэрчилгээнд олгогдсон байна.	100%
1.4	Бүртгэлийн үйлчилгээг мэдээллийн технологийн арга хэрэгслээр үзүүлэх боломжийг нэмэгдүүлэх	-	Улсын бүртгэлийн Цахим /Киоск/ машины тоо	2	3	I-IV улирал	Тус хэлтэс нь улсын бүртгэлийн үйлчилгээг мэдээллийн технологийн арга хэрэгслээр үзүүлэх боломжийг бий болгох хүрээнд маш санаачилгатай ажиллаж Өлгий, Цэнгэл сумдад орон нутгийн хөгжүүлэх сангаас тус бүр 23.0 сая төгрөгийн 2 киоск, энэ онд Цэнгэл, Улаанхус, Ногооннуур, Дэлүүн сумдад тус бүр 7.0 сая төгрөгийн үнэ бүхий 4 ширхэг төлбөрийн Гэрэгэ/киоск/ машин, Толбо суманд 5.0 сая төгрөгийн 1 ширхэг төлбөрийн пос машин шийдвэрлүүлэн хүлээн авч иргэдэд үйлчилгээ үзүүлж байна.	100%
			Улсын бүртгэлийн үйлчилгээний төлбөр тооцооны Гэрэгэ /киоск/ машины тоо	2	3			
1.5	Улсын бүртгэлийн хууль тогтоомж бодлого шийдвэр, үйлчилгээг сурталчилан ажиллах		Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн сурталчилгааны тоо. /нээлттэй хаалга/	4	5	I-IV улирал	Тайлант хугацаанд 5 удаа нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулав. Үүнд: “Хуульчийн Про боно 2023” арга хэмжээ болон Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан аймгийн төв талбайд зохион байгуулагдсан “АЗ ЖАРГАЛТАЙ ГЭР БҮЛ” өдөрлөгийн үеэр тус хэлтсийн албан хаагчид оролцож, Улсын бүртгэлийн хууль тогтоомж, бүртгэлийн үйлчилгээ болон тоон гарын үсгийн талаар эрх зүйн зөвлөгөө, мэдээллийг өгч залуу хосуудад гэрлэлтийн гэрчилгээ олгож ажиллав. Мөн Хэлтсийн даргын баталсан 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн	100%

						удирдамжийн дагуу ажлын хэсэг 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр Сагсай сум, 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр Толбо сум, 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр Бугат сумуудад “Иргэн танд бид үйлчилье” өдөрлөг зохион байгуулж Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйчилгээг үзүүлж нийт 168 иргэнд заавар зөвлөмж өгч ажиллаж, гадаад паспорт 60 иргэнд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 35 бүртгэл хөтөлсөн байна.	
			-хэвлэл мэдээлэл болон цахимаар олон нийтэд сурталчилсан мэдээ, мэдээллийн тоо	124	140	Тус хэлтсийн https://bayan-ulgii.burtgel.gov.mn/ цахим хуудсанд 63, нийгмийн сүлжээний https://www.facebook.com/bayanulgii.burtgel фэйсбук пэйж хуудсаар 137 мэдээллийг олон нийтэд түгээж сурталчлан ажилласан байна. Тайлант хугацаанд орон нутгийн радио телевизээр тус хэлтсээс улсын бүртгэлийн чиглэлээр нийт 17, үүнээс телеизед 4, радиод 13 удаа мэдээллийг олон нийтэд хүргүүлэн ажилласан.	100%
1.6	Улсын бүртгэлийн хууль тогтоомж, холбогдох журмын дагуу эрхлэн хөтлөх	-	-Иргэний улсын бүртгэл хөтөлсөн тоо Цахимжуулсан эх нотлох баримтын тоо	27337	27000	Тайлант хугацаанд иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 39604 иргэн бүртгэлд хамрагдав. Үүнээс 27184 бүртгэл цахимжуулснаас 47569 эх нотлох баримт цахимжуулсан байна.	100%
			-Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтөлсөн тоо	996	700	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр нийт 876 бүртгэл хийсэн болно. Үүнд: Шинээр бүртгэсэн ТБАГУТҮГ 6, ХХК 87, НҮТББ 13, Хоршоо 4, Нөхөрлөл 10, Сан 2, ҮЭХ 4, Нэмэлт өөрчлөлтийн бүртгэл 265, дахин гэрчилгээ 23, нэрийн баталгаажуулалт 310 болно. 2 хуулийн этгээдийн татан буугдах бүртгэлийг бүртгэсэн. Тамга тэмдгийн 174 хяналтын дугаар олгож, ашиглалтын шаардлага хангаагүйн улмаас дахин тэмдэг хийлгүүлэх	100%

							хүсэлтээр 41 тэмдэг хурааж авсан. E-монголиа сайтаар хуулийн этгээдийн нэр болон цахим гэрчилгээ баталгаажуулах нийт 707 хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн хариу өгч ажилласан. МУБИС болон Сэндли ХК-ийн Баян-Өлгий аймаг дахь салбарын нэмэлт өөрчлөлтийг бүртгэж дахин гэрчилгээ олгож ажилласан. Монголын урчуудын эвлэлийн салбарыг шинээр бүртгэж гэрчилгээ олгосон.	
			-Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтөлсөн тоо	7872	6000		Тайлангийн хугацаанд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд үйлчилгээний хураамжийн орлого 82.596.384 төгрөг, үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхээ худалдсанаас оруулсан татварын орлого 315.920.446 төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 16.926.788 төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт оруулсан байна. Нийт 9310 мэдүүлэг хүлээн авч шийдвэрлэснээс анханы бүртгэл 1014, өмчлөх эрх шилжих гэрээ 1201, барьцааны гэрээ 5999, бүртгэлд өөрчлөлт оруулах 837, иргэн хуулийн этгээд лавлагаа, хуулбар 259 тус тус олгож, бүртгэл хөтөлсөн байна. Эд хөрөнгийн эрхийн 171 хувийн хэргийг хаасан байна.	100%
Зорилт 2.Цахим бүртгэлийг хөгжүүлэх замаар улсын бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлнэ.								
2.1	E-mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн порталаар үзүүлэх улсын бүртгэлийн үйлчилгээг хэлтэс, сумдаас үзүүлэх	-	Үзүүлсэн үйлчилгээний төрөл, тоо	191	200	I-IV улирал	Энэ оны эхний 11 сарын байдлаар 215 иргэн цахимаар цахим үнэмлэх, 221 иргэн үндэсний энгийн болон цахим гадаад паспорт захиалан авсан байна. Мөн E-Бизнес сайтаар хуулийн этгээдийн нэр болон цахим гэрчилгээ баталгаажуулах нийт 605 хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн, хариу өгч ажилласан	100%
2.2	Эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг анхан шатны нэгжид	ADB төсөл	Эд хөрөнгийн бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байгаа	5	9	I-IV улирал	Тайлангийн хугацаанд сумдаас Дэлүүн 70, Алтанцөгц 48, Улаанхус 86, Цагааннуур тосгон 34, Алтай 39 бүртгэл тус тус хөтөлсөн байна. Сагсай, Толбо, Бугат сум	

	шилжүүлэх		сумын тоо				сумуудад “Иргэн танд бид үйлчилье өдөрлөг” зохион байгуулсан ба хуулийн этгээдийн чиглэлээр иргэдэд газар дээр нь 23 иргэнд мэдээлэл, зөвлөгөө өгч, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 35 бүртгэл хөтөлсөн байна. Сумдад газар дээр нь эд хөрөнгийн эрхийн бүртгэл нийт 312 хөтөлөн байна. УБЕГазарт үлдсэн сумдад эд хөрөнгийн эрхийн бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэл хөтлөх эрх нээж өгөх талаар санал хүргүүлсэн ба төсөл хэрэгжиж эхэлснээр эрх нээх тухай утсаар хариу авсан болно.	
			Хуулийнн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байгаа сумын тоо	0	2		Хуулийн этгээдийн бүртгэлийг анхан шатны нэгжид шилжүүлээгүй боловч түр эзгүйд орлон ажиллах албан хаагч болон сумдын бүртгэгч нарыг мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж байна.	
2.3	Эд хөрөнгийн өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг цахим хэлбэрээр олгох ажлыг үе шаттайгаар эхлүүлэх /blockchain/	-	Цахим хэлбэрээр олгосон газар өмчлөх эрхийн болон үл хөдлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээний тоо	0	5	I-IV улирал	Тайлангийн хугацаанд нийт цахим хэлбэрээр 3026 гэрчилгээ олгосон байна үүнээс 1625 үл хөдлөх эд хөрөнгө 1401, газар өмчлөх эрхийн гэрчилгээ тус тус олгосон байна.	100%
2.4	Нотариатч мэдүүлэг гаргагчийн хүсэлтээр хуулийн шаардлага хангасан мэдүүлэг, холбогдох баримт бичгийг улсын бүртгэлийн мэдээллийн санд илгээх, бүртгүүлэхэд зуучлах үйлчилгээг нэвтрүүлэх	-	Нотариатчаар зуучлуулан бүртгэсэн бүртгэлийн тоо	0	5	I-IV улирал	Наториатчтай “Мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах гэрээ”-г шинэчлэн байгуулах, дундын мэдээллийн сангаар дамжуулан мэдээлэл нийлүүлэх, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэхэд нотариатч зуучлах үйлчилгээг нэвтрүүлэх хийгдэж эхэлсэн ба манай аймгийн нотариатч нар зуучлах үйлчилгээ хийх талаар гэрээ хийгээгүй байна. Аймгийн хэмжээний тойргын нотариатч Т.Зулай, Е.Халибек нартай 2023 оны 09-р сарын 15-ны өдөр хэлтэст уулзалт зохион байгуулсан ба наториатч нар одоогийн	100%

							байдлаар Улсын бүртгэлийн мэдээллийн сан руу илгээх систем нь ажиллахгүй байгаа тул илгээх боломжгүй байна. Анхны туршилтаар 2 гэрээ илгээсэн боловч Үндэсний дата төвөөс 2023 оны 11-р сарын 1-нээс системийн шинэчлэл хийж Наториатчийн холбогдох гэрээ, хэлцэлийг илгээхэд асуудал гарсан. Наториатчийн программ гүйцэт ажиллахгүй байгаа.	
2.5	Иргэн, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээнд дундын мэдээллийн сан ашиглах	-	-Дундын мэдээллийн сангаар дамжуулан шинээр төрсөн хүүхдүүдэд олгосон регистрийн дугаарын тоо	2750	2800	I-IV улирал	Дундын мэдээллийн сангаас төрөлтийн 2518, нас баралтын 605 бүртгэлийн мэдээллийг дамжуулан олгосон байна.	100%
			-Дундын мэдээллийн сангаар дамжуулан эд хөрөнгийн Е дугаар олгосон тоо	3127	1500		Иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх зорилгоор газар эзэмших, ашиглах /"Э", "А"/ дугаарын автоматаар олгогдсон 1300 дугаарын газар эзэмших, ашиглах эрхтэй холбоотой мэдээллийн хуудсыг системээс хэвлэн дугаарын дараалалын дагуу хадгаламжийн нэгж үүсгэн архивт хүлээлгэн өгч ажиллаж байна.	
2.6	Барьцааны гэрээний болон барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийг цахимаар бүртгэх	-	Цахимаар бүртгэсэн барьцааны гэрээний бүртгэлийн тоо	2437	2500	I-IV улирал	Тайлангийн хугацаанд цахимаар нийт 5999 барьцааны гэрээнд боловсруулалт хийж хууль журмын дагуу бүртгэсэн байна.	100%
			Цахимаар бүртгэсэн барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийн тоо	2193	2200		Нийт 2679 барьцааны гэрээг дуусгавар болгож боловсруулалт хийж, бүртгэсэн байна. Барьцааны гэрээ болон барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийг цахимаар бүртгэх үйл ажиллагааны хүрээнд 2023 оны 09-р сарын 15-ны өдөр Аймаг дахь 5 арилжааны банкны удирдлагатай уулзалт зохион байгуулсан.	100%

							Арилжааны банкуудаас зөвхөн ГОЛОМТ банкны Улаанбаатар хот дахь төв салбар нь цахимаар илгээж байна. Аймгийн салбар банкуудад программ нь хэрэгжиж эхлээгүй 2024 оноос хэрэгжүүлэхээр болсон талаар мэдээлэл өгсөн болно.	
2.7	Улсын бүртгэлийн байгууллагын лавлагаа, хуулбар олгох	-	-Иргэний улсын бүртгэлтэй холбоотой олгосон лавлагаа, хуулбарын тоо	9349	9000	II-IV улирал	Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр нийт 8651 лавлагаа, 356 хуулбар олгосон.	100%
			Хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой олгосон лавлагаа, хуулбарын тоо	287	335		Хуулийн этгээдийн цахим мэдээллийн сангаас иргэн, хуулийн этгээдэд 70 дүрмийн хуулбар, 101 лавлагаа гаргаж өгч, 25 төрийн бус байгууллагын тайлан, Улсын бүртгэлээс хасагдахтай холбоотой хүсэлт гаргасан 62 хуулийн этгээдийн хүсэлтийг тус тус хүлээн авч цахим мэдээллийн санд бүртгэсэн болно.	100%
			Эд хөрөнгийн улсын бүртгэлтэй холбоотой олгосон лавлагаа, хуулбарын тоо, Эрхийн улсын бүртгэлийн тусгай тэмдэглэл хийсэн бүртгэлийн тоо	140	150		Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаар иргэн, хуулийн этгээдэд 100 лавлагаа, 120 хуулбар олгосон байна. Хууль хяналтын байгууллагаас гаргасан албан хүсэлтийн дагуу эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн талаарх 165 лавлагаа мэдээлэлийг албан тоотой хүргүүлэн ажиллаж, 168 эрхийн улсын бүртгэлд тусгай тэмдэглэл хийж, 49 эрх улсын бүртгэлийн эрхийн түдгэлзүүлэн, 35 эрхийн улсын бүртгэлийн эрхийг сэргээж эрх бүхий этгээдийн шийдвэр, хүсэлтийг хувийн хэрэгт нь хавсаргаж цахимжуусан болно.	100%
2.8	Иргэний улсын бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивын	-	Иргэний улсын бүртгэлийн бичиг баримтын архивын нэгдсэн тоо	169993	172493	I-IV улирал	Өнөөдрийн байдлаар иргэний баримт бичгийн архивт 172251 хувийн хэрэг хадгалагдаж байна.	100%

	баримтын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх нэгдсэн тоо бүртгэлийн тоо		Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын нэгдсэн тоо	33516	34716		Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивт 34735 хувийн хэрэг хадгалагдаж байна. Үүнээс 16145 газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө, 13713 газар өмчлөх эрхийн бүртгэл, 4877 газар эзэмших эрхийн бүртгэл, 6 нь ашиглах эрхийн хувийн хэрэг байна.	100%
			Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн бичиг баримтын архивын нэгдсэн тоо	2400	2532		Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивын тоо бүртгэлийг тухай бүр хөтөлж байгаа ба одоогийн байдлаар 2536 хуулийн этгээд бүртгэлтэй байна.	100%
Зорилт 3.Улсын бүртгэлийн мэдээллийн аюулгүй байдал, нэгдсэн сангийн нууцлалыг ханган, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.								
3.1	Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах	-	Эрсдэлийн төлөвлөгөөний биелэлт, хувиар	100	100	I-IV улирал	Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2023 онд тодорхойлогдсон эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан тус хэлтсийн эрсдэлийн биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 728 тоот албан бичгээр хүргүүлэн ажилласан.	90%
3.2	Улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан дахь алдаатай бүртгэлд дүгнэлт гарган, мэдээллийн санд зөвтгөх	-	Зөрчил арилгасан нийт дүгнэлтийн тоо	255	100	I-IV улирал	-Хуулийн этгээдийн цахим мэдээллийн санд зөрүүтэй бүртгэгдсэн болон тамга, тэмдгээ үрэгдүүлсэн 10, хувийн хэргийн эх нотлох баримтаас цахим мэдээллийн санд зөрүүтэй, орхигдож бүртгэгдсэн 6 хуулийн этгээдийн хүсэлтийг Хяналтын улсын ахлах байцаагчийн 2022 оны 806, 2023 оны 5051 дугаар дүгнэлтээр тус тус цахим санд зөвтгөсөн. -ЭХЭУБүртгэлийн мэдээллийн санд цахимжуулалтын үеэр буруу цахимжсан, төлөв буруу сонгосон хувийн хэргүүдийг эх нотлох баримт болон цаасан нотлох баримттай нь тулган шалгаж, улсын байцаагчийн 1500 дугаар дүгнэлтээр 600 бүртгэлийг зөвтгөсөн. Хэлтсийн хяналтын улсын байцаагчийн 57 удаагийн дүгнэлтээр эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд	100%

						<p>чиглэлээр засвар өөрчлөлт оруулсан байна.</p> <p>-Мэдээллийн санд алдаатай Регисртийн дугаар өөрчилсний бүртгэл / ИУБ-25 / хоёроос дээш удаа бүртгэсэн 31 иргэний жагсаалтыг ИУБГ-аас хүлээн авч мэдээллийн сангаас шалгаж 27 иргэний Регисртийн дугаар өөрчилсний бүртгэл нь давхар бүртгэгдсэн төлөвийг хүчингүй болгуулахаар хяналтын улсын байцаагчид шилжүүлж 3846 дугаартай дүгнэлт гаргуулан мэдээллийн санг зөвтгүүлсэн. Төрсний бүртгэл, үрчилсний бүртгэл, ОНӨ-ний бүртгэл, шилжин ирсний нийт 9 бүртгэлүүд бүртгэсэн төлөвтэй төрсний 2 бүртгэл, үрчилсний 1 бүртгэл, ОНӨ-ний 1, шилжин ирсний 2 бүртгэлийг хүчингүй болгуулахаар, мөн үрчилсний 2 бүртгэл, шилжин ирсний 1 бүртгэлийг баталгаажуулахаар хяналтын улсын байцаагчийн 3847, 3889 дүгнэлтүүдийг гаргуулан хүргүүлж зөрчлийг арилгуулсан. 2023 оны 9 дүгээр сарын 20-ний өдрийн илтгэх хуудсаар явуулсан төрөлтийн 1, гэрлэлтийн 1 бүртгэлүүд ХУБ-ын 5698 дүгнэлтээр зөрчил нь арилгуулсан.</p>	
3.3	Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих замаар улсын бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг хангах	-	Хяналт шалгалтын төлөвлөгөө гаргаж батлуулах, төлөвлөгөөний биелэлтийн хувь	100	100	<p>I-IV улирал</p> <p>Хяналт шалгалтын 2023 оны төлөвлөгөөг батлуулан, хэрэгжилтийг бүрэн хангаж, шаардлагатай дараах арга хэмжээг авч ажиллаж байна. .</p> <p>Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, ерөнхий байцаагчийн хяналт шалгалт хийх тухай удирдамж, Хяналт шалгалтын газраас ирүүлсэн үүрэг чиглэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар, Иргэний улсын бүртгэлийн газар, Архивын газраас тус тус ирүүлсэний дагуу 2023 онд бүртгэгдсэн нийт 17308 улсын бүртгэлд урьдчилан сэргийлэх хяналт</p>	100%

							шалгалт 14, төлөвлөгөөт бус хяналт шалгалт 162, гүйцэтгэлийн хяналт шалгалт 15 удаа хийж, илрүүлсэн зөрчилд тэмдэглэл үйлдэж зөрчил арилгах тухай 14 албан шаардлагыг холбогдох тус хэлтсийн улсын /ахлах/ бүртгэгч, улсын бүртгэгч, архивч, 13 сум 1 тосгоны улсын бүртгэгч нарт хүргүүлэн зөрчил арилгуулах арга хэжээ авч ажилласан байна. Тайлангийн хугацаанд улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журамд заасны дагуу улсын бүртгэлийн алдаа зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, улсын бүртгэлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор тус хэлтсийн улсын бүртгэгч нарын хөтөлсөн 19868 гаруй улсын бүртгэлд байнгын хяналт тавьсан, 17308 бүртгэлийг хяналт шалгалт хийж ажилласан болно. Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналт шалгалтын газрын 2023 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 6/3387 тоот албан бичгээр ирүүлсэн Хяналтын улсын ахлах байцаагчийн мөн өдрийн №13 дугаар Иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын ахлах бүртгэгчийн гаргасан зөрчлийг арилгуулах албан шаардлагын дагуу зөрчлийг арилгуулахаар шаардлага тавьж, зөрчлийг арилгах зорилгоор бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэл хүчингүй болгох тухай 156 гаруй бүртгэлд дүгнэлтийг гаргасан байна.	
3.4	Хэлтсийн санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, төсвийн хөрөнгийг зүй зохимтой зарцуулах, тайлагнах, байршуулах, санхүүгийн дотоод	-	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн хувь	98,9	100	I-IV улирал	Шилэн дансанд оруулах мэдээллүүдийг тухай бүр бүрэн оруулж ажиллаж байна.	100%
			Тайлагнаж, байршуулсан мэдээллийн хувь	100	100		Тайлант хугацаанд шилэн дансанд оруулах ёстой 139 мэдээллийг байршуулсан. Үүнд: тухай бүр оруулах 90,	100%

	аудитыг хэрэгжүүлэх						сар бүр оруулах 40, хагас жилээр оруулах 4, бүтэн жилээр оруулах 5 мэдээлэлийг хуулийн хугацаанд оруулсан.Биелэлт 100% байна.	
3.5	Аймгийн аудитын газраас болон ерөнхий газраас ирүүлсэн зөвлөмжид хяналт тавих, мэдээ мэдээлэл, тайланг хугацаанд нь хүргүүлэх	-	Зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийг хувь	100	100	I-IV улирал	Тус хэлтсийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийлгэсэн ба ямар нэгэн зөвлөмж өгөгдөөгүй. Аймгийн аудитын газраас болон ерөнхий газраас ирүүлсэн зөвлөмжийг дагаж мөрдөн ажиллаж байна Санхүүгийн сарын мэдээ болон тайланг цаг тухайд хүргүүлэн ажиллаж байна.	100%
Зорилт 4. Улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаар орон нутгийн удирдлагуудтай, төрийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллана.								
4.1	Аймаг сумдын ИТХ, Засаг дарга, болон төрийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж дэмжлэг авах	-	Санал тавьж шийдвэрлүүлсэн эсэх; Архивын байрны хадгалалт, хамгаалалт, хадгаламжийн сангийн нөхцөл байдлыг сайжруулах; Сумдаас архивын цаасан эх нотлох баримтыг баталгаат шуудангаар татан авахад дэмжлэг авах биелэлтийн хувь	50	100	I-IV Улирал	Эд хөрөнгийн эрхийн усын бүртгэл хөтлөх эрх нээгдсэн 5 сумдын Засаг дарга нартай хамтран ажиллах хүрээнд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын эх нотлох баримтыг баталгаат шуудангаар хүргүүлэн авч ажиллаж байна.	100%
			Уулзалт зохион байгуулсан тоо	4	5		Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөр 10.000.000 /арван сая/ төгрөгний тоног, төхөөрөмж худалдан авсан болно. Сумдын Засаг дарга, удирдлага нартай хамтран ажиллаж, санал хүргүүлснээр орон нутгийн хөгжүүлэх сангаас Цэнгэл, Улаанхус, Ногооннуур, Дэлүүн сумдад тус бүр 7.0 сая төгрөгийн үнэ бүхий 4 ширхэг төлбөрийн Гэрэгэ/киоск/ машин, Ногооннуур сум сүлжээний медиа конвертор шинээр авхаад 300.000 төгрөг, Улаанхус сум сүлжээний роутер 600.000 төгрөг, Толбо суманд 5.0 сая төгрөгийн төлбөрийн пос машин шийдвэрлүүлэн хүлээн авч иргэдэд үйлчилгээ үзүүлж байна. Нийт орон нутгийн төсвөөс 43,900.000 төгрөгийг шийдвэрлүүлсэн байна. 2024 оны төсвийн төсөлд үлдсэн сумдад киоск машин худалдаж авахаар санал	100%

							хүргүүлэн ОНХС-аас хэлтэст 1, Алтай, Булган, Сагсай 3 сумаас тус бүр 23.0 сая төгрөгийн улсын бүртгэлийн киоск шийдвэрлэж өгөхөөр болсон.	
Зорилт 5. Чадахуйн зарчимд суурилсан хүний нөөцийг бүрдүүлж, албан хаагчдын нийгмийн баталгааг хангана.								
5.1	Хэлтсийн 2023 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг батлаж, хэрэгжүүлэх	-	Сургалтын төлөвлөгөөний биелэлтийн хувь	100	100	I-IV улирал	<p>Хэлтсийн сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан 29 сургалт 100% биелсэн. УБЕГазрын сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан 17 удаагийн сургалтад албан хаагчид цахимаар бүрэн хамрагдсан. Төрийн албаны зөвлөлөөс 7:4:10 зохион байгуулсан сургалтад нийт 39 удаагийн сургалтад албан хаагчид тухай бүр хамрагдсан байна.</p> <p>Бүгд Найрамдах Солонгос улсын шүүхийн дэргэдэх сургалтын төвд зохион байгуулсан МУ-ын Үндэсний бүртгэлийн системийн дижитал чадамжийг бэхжүүлэх хөтөлбөрт хэлсийн дарга 14 хоногийн сургалтад хамрагдаж оролцсон.</p> <p>ЗГХЭГ-ын дэргэдэх Удирдлагын академийн төрийн захиргааны албан хаагчдад зориулсан ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1, богино хугацааны сургалтад 2 албан хамрагдаж, амжилттай суралцаж төгссөн.</p> <p>Аймгаас зохион байгуулсан Алсын хараа 2020-2050, мөн төрийн албан хаагчдыг чадавхжуулах 7 удаагийн сургалтад холбогдох албан хаагчдыг тус тус хамруулсан болно.</p> <p>Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 2/9641 тоот “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийн дагуу албан хаагчдад үүрэг даалгавар өгч тус хэлтсийн 31 албан хаагч Хүний нөөц сургалтын системийн Бие даах хичээлүүдийг судлан үзэж, бүх шалгалтуудыг нэг бүрчлэн өгсөн болно.</p>	100%

5.2	Албан нийгмийн хаагчдын баталгаа хангах хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх.	-	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	80	100	I-IV улирал	Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор 3 албан хаагчдад 250,0 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж урамшуулал олгосон.	100%
-----	---	---	-------------------------------	----	-----	-------------	---	------

Төлөвлөгөөг хянасан:

Төсвийн Ерөнхийлөн захирагч

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА...../Д.ДЭЛГЭРСАЙХАН/

(албан тушаал)

(гарын үсэг)

Тэмдэг

.....
(огноо)

Төлөвлөгөө тайлагнасан :

Төсвийн шууд захирагч

ХЭЛТСИЙН ДАРГА/Х.АМАНГҮЛ/

(албан тушаал)

(гарын үсэг)

Тэмдэг

2023.11.27
(огноо)